



## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

### ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Бага тойруу, Хуульчдын талбай, Утас/Факс: (976-51) 26 26 37,  
И-мэйл: turintusgaiemneleg@gmail.com,  
Вэбсайт: www.ghsss.gov.mn

2020.01.21 № 76  
танай \_\_\_\_\_-НЫ № \_\_\_\_\_-Т

#### Залруулга хүргүүлэх тухай

Тус эмнэлгээс цахим хэлбэрээр зарласан Даатгалын үйлчилгээ үзүүлэх ТТАХНЭ/202012013 дугаар бүхий тендерийн баримт бичигт тавигдаж буй зарим шаардлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Даатгалын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг тодруулах шаардлагатай гэж үзсэн тендерт оролцогчийн хүсэлт үндэслэлтэй байх тул тендерийн баримт бичигт дараах залруулгыг оруулж байна. Үүнд:

Нэг. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТӨӨЗ 4.2 (е)-д “санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо нь 2018, 2019 оны жилийн эцэс” гэснийг “санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо нь 2018 оны жилийн эцэс, 2019 оны эхний хагас жил” гэж өөрчлөв.

Хоёр. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТӨӨЗ 12.1-д

- Давхар даатгалтай байх (нотолгоо баримт ирүүлнэ, нотолгоо баримтыг Монгол хэл рүү орчуулсан байх)

- Сүүлийн 2 жилд хөрөнгийн даатгалаар давхар даатгагчаас томоохон нөхөн төлбөр төлүүлсэн туршлагатай байх (нотолгоо баримт ирүүлнэ, нотолгоо баримтыг Монгол хэл рүү орчуулсан байх)


- Даатгалын нөөц сангийн үлдэгдэл 2 (хоёр) тэрбум төгрөгөөс багагүй байх

- Эрүүл мэндийн салбарт даатгалаас бусад тодорхой ажил хийж гүйцэтгэсэн байх (ажлын тайланг ирүүлэх) гэж нэмж оруулав.

Гурав. Тендерийн баримт бичгийн 28 дугаар хуудасны “Техникийн шаардлага” гэсэн хэсэгт эмнэлгийн тоног төхөөрөмжийн марк, сериал дугаар, ашиглалтад орсон огноо, анхны өртгийн талаарх мэдээллийг Хавсралт 1-ээр оруулав.


Тендерт оролцогчдыг тендерийн баримт бичигт дээрх залруулгыг оруулж бэлтгэн ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

ЗАХИРАЛ,  
ДЭД ХУРАНДАА



Л.БАТТӨР

ТТАХНЭ-ийн 2020 оны 01 сарын  
21-ны өдрийн 76 тоот албан  
бичгийн хавсралт



ДААТГУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Сериал дугаар	Ашиглалтанд авсан огноо	Анхны өртөг
1	Digital Fluoroscopy, remote control system Дижитал флюороскопи	Luminos DFR Max	SN(21) 13354	2018.12.25	1,913,034,284.2
2	Radiography & Fluoroscopy portable (= c-arm) Зөөврийн рентген аппарат	Siemens c arm	01JN17911	2018.12.25	498,738,732.2
3	Digital X-ray Дижитал рентген аппарат	Ysio max	SN(21) 13420	2018.12.25	1,847,288,272.4
4	3D ultrasound system (Ob/Gyn, Abdomen, Pediatric, 3D хэт авиан оношлогооны багаж/ эх барих, эмэгтэйчүүд/	ACUSON S2000	SN(21) 214863	2018.12.25	334,344,643.4
5	Cardiac ultrasound system Зүрхний хэт авиан оношлогооны багаж	ACUSON X700	SN 362097	2018.12.25	477,036,748.8
6	Duplex Ultrasound (incl. Transcranial transducer) Дуплекс хэт	ACUSON X300	SN 352085	2018.12.25	298,475,249.5

	авиан оношлогоо				
7	MRI Цахилгаан соронзон давтамжит оношлогооны аппарат	Brivo MR 335	SN 6120570007611100014	2018.05.31	3,421,624,840.0
8	CT Компьютер томографик	CT optima 660	SN 39623YC4	2017.05.31	1,411,506,000.0